



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДАА-2022/125/НА-СА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Дархан-Уул аймаг 2022 он	Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын албан үүргийн түр орлон гүйцэтгэгч: Ш.Мөнхбаяр Утас: 70378845 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn Ахлах аудитор: С.Батцэцэг Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn Ахлах аудитор: У.Батсүрэн Утас: 70373089 Цахим хаяг: batsurenu@audit.gov.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу

2022.08.24	No	122
total	100	100



АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Стандарт, хэмжил зүйн хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж тодиргуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭН

Ц.МӨНХБАЯР



009029124

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	46,485,711.72	37,446,915.42
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	651,539,126.04	658,961,044.26
	Нийт хөрөнгийн дүн	698,024,837.76	696,407,959.68
	Нийт өр төлбөрийн дүн	-	17,391,000
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	698,024,837.76	679,016,959.68
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	698,024,837.76	696,407,959.68
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	437,140,424.00	496,150,959.50
	Үйл ажиллагааны зардлын дүн	434,640,198.92	515,116,764.08
	Үйл ажиллагааны үр дүн	2,500,225.08	(18,965,804.58)
	Үйл ажиллагааны бус үр дүн	-	(42,073.50)
	Үйл ажиллагааны нийт үр дүн	2,500,225.08	(19,007,878.08)
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	695,524,612.35	698,024,837.76
	Тайлант оны үр дүн	2,500,225.08	(19,007,878.08)
	Эцсийн үлдэгдэл	698,024,837.76	679,016,959.68
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	422,748,207.00	488,052,628.00
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	412,400,007.00	473,422,428.00
	Үйл ажиллагааны ЦМГ	10,348,200.00	14,630,200.00
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	(10,348,200.00)	(14,630,200.00)
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	359,842,300.00	358,712,956.98
	Урсгал зардал	359,842,300.00	358,712,956.98
	Хөрөнгийн зардал	-	-
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	359,842,300.00	378,978,866.02
	Улсын төсвөөс санхүүжих	218,842,300.00	217,712,956.98
	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	141,000,000.00	161,265,909.04
	Оны эхний үлдэгдлээс санхүүжих	-	-

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дархан-Уул аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтэс нь Хэмжил зүйн тухай хуульд заасны дагуу холбогдох хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, ажлын эталоныг бий болгох, хадгалах, ашиглах, тэдгээрийн нэгж дамжуулалтыг хангах, хэмжих хэрэгсэлд шалгалт баталгаажуулалт, тохируулга хийх зэрэг хэмжлийн нэгдмэл байдлыг хангах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал, санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Дөрөв. Аудитын гол асуудал

Стандарт, хэмжил зүйн хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал байхгүй.

Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн 6 дугаар зүйлд заасныг хэрэгжүүлж ажилласан байна гэж дүгнэлээ.

Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц чухал асуудал байхгүй болно.

Долоо. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 1,488.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрсэнд цаашид үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах 2 зөвлөмж өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитын явцад залруулсан алдаа байхгүй болно.

4.2 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоох зөрчилтэй асуудал гараагүй болно.

4.3 Албан шаардлага

Албан шаардлага хүргүүлэх зөрчилтэй асуудал гараагүй болно.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Цалингийн зардалтай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Тайлант онд батлагдсан цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардлаас аймгийн Засаг даргын 2021 оны 01-А/200 дугаар захирамжаар хэлтсийн дарга И.Алтанцэцэгт 1,088.7 мянган төгрөгийн мөнгөн шагнал, хэлтсийн даргын 2021 оны Б/20 дугаар тушаалаар 4 ажилтанд 400.0 мянган төгрөгийн нүүрсний хөнгөлөлт тус тус олгосон байна. Мөн бичиг хэрэг, мөнгөн кассын нярваар томилогдсон ажилтны албан тушаал өөрчлөгдөөгүй байхад хэлтсийн даргын 2021 оны А/01 дүгээр тушаалаар хүний нөөцийн ажилтны албан тушаалын ТҮ-7-5 зэрэглэлээр тогтоож цалинжуулан 2,331.0 мянган төгрөг илүү олгожээ.

1.2. Өгсөн зөвлөмж:

- Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан зардлын эдийн засгийн ангиллын дагуу зардлыг бүртгэж тайлагнах
- Засгийн газрын 2019 оны 276 дугаар тушаалаар баталсан төрийн үйлчилгээний бусад байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын зэрэглэлийн дагуу цалингийн зэрэглэлийг тогтоох

2. Эд хөрөнгийн тооллого

2.1. Илрүүлэлт:

Хэлтсийн даргын 2021 оны А/09 дүгээр тушаалд заасны дагуу 11 дүгээр сард жилийн эцсийн тооллого зохион байгуулснаас санхүүгийн тайлангийн хөрөнгө, тооллогын дүнгээс зөрүүтэй илэрхийлэгдсэн.

2.2. Өгсөн зөвлөмж:

- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасан хугацаанд Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу эд хөрөнгийн тооллогыг зохион байгуулж байх

7.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1			1			

7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

(сая төгрөгөөр)

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	ТШЗ	2	3.8	-	-	-	-	-	-	2	3.8
2	Төсөл, хөтөлбөр	-	-	-	-	-	-	-	-	-	-
3	ЗГТС	-	-	-	-	-	-	-	-	-	-
4	ТТЗ	-	-	-	-	-	-	-	-	-	-
5	ТЕЗ	-	-	-	-	-	-	-	-	-	-
	НИЙТ	2	3.8	-	-	-	-	-	-	2	3.8